



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 511

Улаанбаатар хот

Б.Энхтөрийг ажилд томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 01/408 дугаар албан бичиг болон Авлигатай тэмцэх газрын 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 05/15670 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан “Геологийн судалгаа шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Баярсайханы Энхтөрийг 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. “Геологийн судалгаа шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын нээлттэй сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

3. “Геологийн судалгаа шинжилгээний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Энхтөртэй “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ